



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

# БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ  
2022 он

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

**БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2022 оны 06 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд:</b>							
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.							
3.4 заалт. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.							
<b>Зорилт 1: 3.4.1. Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна.</b>							
3.4.1.1. Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг нэмэгдүүлнэ.							
1.1.1.	<b>Арга хэмжээ-1:</b> Үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг шинээр байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 80.0 сая.төг	Тоо	4	5	-Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Улаанбаатар хотын жуулчны мэдээллийн төв ажиллуулах тухай” А/210 дугаар захирамжийн хүрээнд гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор Нийслэлийн Засаг захиргааны IV байр, “Хонхор тосгон”, “Хөшиг”-ийн хөндийн “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын “Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төв”-үүдийг тогтмол ажиллуулж, Үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг шинээр Ж.Сүхбаатарын талбайд зөөврийн зориулалтаар, “Төв шуудан”, “Улаанбаатар төмөр замын буудал”-д ажиллуулахаар судалгаа хийж, зураг төслийг боловсруулж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70%
1.1.2.	<b>Арга хэмжээ-2:</b> Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвөөр дамжуулан гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт	/-/	Иргэд, жуулчдын тоо	2970	3000- 4000	-Гадаад, дотоодын жуулчдын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, мэдээлэл, зөвлөгөөг түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэх зорилгоор Жуулчны лавлах утас 70108687 дугаар ажиллуулж 2022 оны эхний хагас	70%

	мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх					жилийн байдлаар нийт 4300 гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээлэл өгч ажиллалаа. -Тайлант хугацаанд аялал жуулчлалын 2 арга хэмжээ, 2 үзэсгэлэнд “Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг ажиллуулж 3500 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээлэл өгсөн.	
3.4.1.2. Улаанбаатар хотын онцлог бүхий брэндийг хөгжүүлж, соёл, аялал жуулчлалын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, шинэ аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлнэ.							
1.1.3.	<b>Арга хэмжээ-3:</b> “Талын салхи” олон улсын мото наадам арга хэмжээ зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 20.0 сая.төг	Оролцогч, сонирхогчдын тоо	5000	5000- 6000	-Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/770 дугаар захирамжийн хүрээнд “Монголын чопперчин ахан дүүс” ТББ-тай хамтран мотоцикл сонирхогчдын дунд “Талын салхи” олон улсын мото наадмыг “Эрүүл хүн-Архигүй Монгол” уриан дор жанжин Д.Сүхбаатарын талбайд 2022 оны 06 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулав. - “Талын салхи” олон улсын мото наадмын үеэр мото дагалдах хэрэгслийн үзэсгэлэн худалдаа, ховор нандин мотоциклын үзүүлэн, танилцуулга, тэмцээн уралдаан, соёл урлагийн тоглолт зохион байгуулагдаж, парадад Монгол Улсын 21 аймгийн 45 клубын 1086, ОХУ-ын 114 нийт 1200 мото спорт сонирхогч оролцож, арга хэмжээг 15.000 гаруй хүн үзэж сонирхсон.	100%
1.1.4.	<b>Арга хэмжээ-4:</b> “Дээлтэй Монгол наадам” арга хэмжээ зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 35.0 сая.төг	Оролцогч, сонирхогчдын тоо	7000	7000- 8000	Хугацаа болоогүй.	-
1.1.5.	<b>Арга хэмжээ-5:</b> “PLAY TIME” олон улсын амьд хөгжмийн наадам арга хэмжээ зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 5.0 сая.төг	Оролцогч, сонирхогчдын тоо	30000	30000- 35000	Хугацаа болоогүй.	-
1.1.6.	<b>Арга хэмжээ-6:</b> “Улаанбаатар үндэсний хоолны өдөрлөг” арга хэмжээ зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 30.0 сая.төг	Оролцогч, сонирхогчдын тоо	1000	1000- 1500	Хугацаа болоогүй.	-

1.1.7.	<b>Арга хэмжээ-7:</b> “Улсын соёлын өдрүүд” арга хэмжээг зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 20.0 сая.төг	Оролцогч, сонирхогчдын тоо	3000	5000- 8000	-Улаанбаатар дахь Аллианс Франсез төв, Монгол Улс дахь Францын төлөөлөгчийн газартай хамтран “Францын соёлын өдрүүд”-ийг тохиолдуулан “Франц хэлтэн орнуудын хотхон” үзэсгэлэн, соёл, аялал жуулчлалын өдөрлөгийг 2022 оны 03 дугаар сарын 27-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, арга хэмжээнд сургалт судалгааны байгууллага, аялал жуулчлалын компани, ресторан, төрийн бус байгууллага, франц хэлтэн орнуудын дипломат төлөөлөгчийн газар зэрэг 40 гаруй байгууллага оролцож, франц хүнсний бүтээгдэхүүн амталгаа, шөлний тэмцээн, урлаг, соёлын арга хэмжээг нийт 3000 гаруй хүн үзэж сонирхсон. - Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах тухай” А/530 дугаар захирамжийн дагуу Унгар Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран “Унгарын соёлын өдрүүд”-ийг Шангри-ла төв, жанжин Д.Сүхбаатарын талбайд 2022 оны 05 дугаар сарын 13,14-ний өдөр Унгар хоолны амталгаа, хүнс, виноны амталгаа, текболын танилцуулга, урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулж арга хэмжээг 3000 гаруй хүн үзэж сонирхсон.	100%
1.1.8.	<b>Арга хэмжээ-8:</b> “Хийморь” олон улсын морьт харвааны наадам арга хэмжээ зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 20.0 сая.төг	Оролцогч, сонирхогчдын тоо	3000	3000- 5000	Хугацаа болоогүй.	-
1.1.9.	<b>Арга хэмжээ-9:</b> “Улаанбаатар” явган аяллын фестиваль арга хэмжээ зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 15.0 сая.төг	Оролцогч, сонирхогчдын тоо	150	200-250	Хугацаа болоогүй.	-
1.1.10.	<b>Арга хэмжээ-10:</b> “Уухай” шагайн харвааны наадам арга хэмжээ зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 15.0 сая.төг	Оролцогч, сонирхогчдын тоо	500	1000- 2000	Хугацаа болоогүй.	-



1.1.11.	<b>Арга хэмжээ-11:</b> “Хуралдайн наадам-Шонхорын баяр” арга хэмжээ зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 5.0 сая.төг	Оролцогч, сонирхогчдын тоо	500	1000- 2000	Хугацаа болоогүй.	-
1.1.12.	<b>Арга хэмжээ-12:</b> “Хаадын чуулбар” Чингис хааны мэндэлсэн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 35.0 сая.төг	Оролцогч, сонирхогчдын тоо	-	1000- 2000	Хугацаа болоогүй.	-
1.1.13.	<b>Арга хэмжээ-13:</b> Улаанбаатар брэнд төсөл арга хэмжээг үргэлжлүүлэн хотын брэндийг хөгжүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан сурталчлах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 20.0 сая.төг	Тоо	6	9	-Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/439 дүгээр захирамжийн хүрээнд жуулчдад зориулсан 15 нэр төрлийн бүтээгдэхүүн гаргах, мөн Улаанбаатар брэнд лого, өнгө дизайн, уриа үг бий болгох ажлыг “Кью Эн Эс” ХХК-ийн Хөсөг төслийн багаар гүйцэтгүүлж байна.	50%
<b>3.4.1.3. Жуулчдын зорин очих газрын дэд бүтцийг сайжруулж, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ</b>							
1.1.14.	<b>Арга хэмжээ-14:</b> “Их тэнгэрийн амны хадны зураг” орчныг тохижилтын ажлыг үргэлжлүүлж, аяллын бүтээгдэхүүн бий болгох	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 40.5 сая.төг	Хувь	30%	100%	-Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/676 дугаар захирамжийн хүрээнд “Их тэнгэрийн амны хадны зургийн орчныг тохижуулах ажил”-ын гэрээг “Жи Эн Зэт Эф Икс” ХХК-тай байгуулж, тохижилтын ажлыг 2022 оны 04 дүгээр сараас эхлүүлж гэрээгээр хүлээсэн үүргийг хангуулж тогтмол хянан ажиллаж байна. Тохижилтын ажлын хүрээнд явган хүний зам, авто машины зогсоол /12/, хадны зураг руу гарахад зориулсан шат, сандал, танилцуулга самбар, ногоон байгууламжийн ажлууд хийгдэж байна.	70%
1.1.15.	<b>Арга хэмжээ-15:</b> “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш” орчныг тохижилт, бүтээн байгуулалтын ажлын зураг төсөл, төсвийг боловсруулж батлуулах	/-/	Батлагдсан зураг, төсвийн тоо	-	1	-Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах төсөл, арга хэмжээний хүрээнд “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш” орчны тохижилт, бүтээн байгуулалтын ажлын зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраар, тохижилтын ажлын зураг, төсвийг	100%

						“Батдах” ХХК-иар гүйцэтгүүлж нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газраар батлуулсан.	
1.1.16.	<b>Арга хэмжээ-16:</b> “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш” гаднах орчныг тохижуулах	Нийслэлийн төсөв 700.0 сая.төг	Хувь	-	100%	-Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Эрх шилжүүлэх тухай” А/219 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах төсөл, арга хэмжээний эрхийг тус газарт шилжүүлсний дагуу НХААГ/202212090 тендер шалгаруулалтын дугаартай 3 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, НХААГ/202212090-1 багц буюу “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш” цогцолборын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Өндөрхаан-Өргөө” ХХК-тай гэрээ байгуулж, тохижилтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	50%
1.1.17.	<b>Арга хэмжээ-17:</b> “Ар гүнт дэх дөрвөлжин булш” түүх, соёлын дурсгалын орчныг тохижуулж, аялал жуулчлалын эргэлтэд оруулах	Нийслэлийн төсөв 200.0 сая.төг	Хувь	-	100%	-Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах НХААГ/202212090 тендер шалгаруулалтын дугаартай 3 багц ажлын тендерийг зохион байгуулсан. НХААГ/202212090-3 багц буюу “Ар гүнт дэх дөрвөлжин булш” түүх, соёлын дурсгалын орчныг тохижуулах ажлын тендер шалгаруулалтын үнэлгээг хийхэд шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул холбогдох хууль, журмын дагуу тендерээс татгалзсан. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоосон.	70%
1.1.18.	<b>Арга хэмжээ-18:</b> “Гачууртын амны хадны зураг” түүх, соёлын дурсгалын орчныг	Нийслэлийн төсөв 100.0 сая.төг	Хувь	-	100%	-Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах төсөл, арга хэмжээний	100%

	тохижуулж, аялал жуулчлалын эргэлтэд оруулах					худалдан авах ажиллагааны гүйцэтгэчийг сонгон шалгаруулах НХААГ/202212090 тендер шалгаруулалтын дугаартай 3 багц ажлын тендерийг зохион байгуулсан. НХААГ/202212090-2 багц буюу “Гачууртын амны хадны зураг” түүх, соёлын дурсгалын орчныг тохижуулах ажлын тендер шалгаруулалтын үнэлгээг хийхэд шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул холбогдох хууль, журмын дагуу тендерээс татгалзсан. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоосон.	
1.1.19.	<b>Арга хэмжээ-19:</b> “Туулын Хар Түнийн ордны туурь” орчмын тохижилт, бүтээн байгуулалтын эскиз зургийг боловсруулах	-	Боловсруулсан зургийн тоо	-	1	-Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах ажлын хүрээнд “Туулын Хар Түнийн ордны туурь” орчмын тохижилт, бүтээн байгуулалтын ажлын зураг, төсвийг боловсруулах ажлын даалгаврыг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраар батлуулсан. - Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнтэй хамтран эскиз зургийг боловсруулав.	100%
1.1.20.	<b>Арга хэмжээ-20:</b> Гадаад дотоодын жуулчдыг татах хотын аяллын шинэ бүтээгдэхүүн бий болгох	Нийслэлийн төсөв 80.0 сая.төг	Тоо	-	1	-Улаанбаатар хотод ердийн хэсгийн аяллыг нэвтрүүлэх, гадаадын жуулчин, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, нүүдлийн соёл иргэншлийг өвлөх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор хөсөг тэрэгний аяллыг зохион байгуулахаар төлөвлөн судалгааны ажил хийгдэж байна.	50%
1.1.21.	<b>Арга хэмжээ-21:</b> “Гандангийн дэнж” шинэ аялал жуулчлалын бүсийн зураг, төсөв боловсруулах ажилд санал өгөх	-	Саналын тоо	-	1	Хугацаа болоогүй.	
1.1.22.	<b>Арга хэмжээ-22:</b> Богдхан уулын явган аяллын маршрутын зураг төсвийг	Улсын төсөв 400.0	Саналын тоо	-	1	-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалтай нутгийн удирдлагын газар болон холбогдох байгууллагуудтай	100%

	боловсруулах ажилд санал өгөх					хамтран Богдхан ууланд явган аяллын замын маршрут гаргах, аялах боломжийг бүрдүүлэх хашаа хайсыг нээх талаар судалгааны ажлыг зохион байгуулсан. Богдхан уулын дархан цаазат газрын явган аяллын маршрутын зураг төсөв боловсруулах ажлын даалгаварт санал тусган Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох газарт хүргүүлсэн.	
1.1.23.	<b>Арга хэмжээ-23:</b> Ар зайсангийн гудамжнаас Дугуй цагаан хүртэлх уулын алхалтын замын тохижилтын ажилд санал өгөх	-	Саналын тоо	-	1	-Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/370 дугаар захирамжаар байгуулагдсан Богдхан уулын “Авто зогсоол-Дугуй цагаан” чиглэлийн явган аяллын замыг тохижуулах ажлын хэсэгт тохижилтын ажлын даалгавар болон зураг, төсөлд явган аяллын замын тохижилтын ажлын саналыг хүргүүлэв.	100%
1.1.24.	<b>Арга хэмжээ-24:</b> Авто машингүй гудамж арга хэмжээг зохион байгуулахад санал өгөх /Өглөөний гудамж, Аялал жуулчлалын гудамж/	-	Саналын тоо	1	1	-Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/292 дугаар захирамжийн хүрээнд цагийн хязгаартай ажиллах авто машингүй гудамж, талбайн судалгааг гаргах, төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд Соёлын яам, нийслэлийн “Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ, “Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦК” ХХК-ийн удирдлага холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулсан. -Улаанбаатар хотод соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, чөлөөт уран бүтээлчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор Сүхбаатар дүүрэгт байрлах Үндэсний соёл амралтын хүрээлд “Метро стрийт” гэрэлт гудамжны тохижилтын ажлын зураг төсөлд тусгах саналыг Нийслэлийн Хот тохижилтын газарт хүргүүлсэн. - Улаанбаатар хотод эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, ажлын байрыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын цогцолбор бий болгох зорилгоор Сонгинохайрхан дүүрэгт байрлах “Шувуут нуур”-ыг аялал жуулчлалын мега гудамж	100%



						болгох хүрээнд тохижилтын ажлын зураг төсөлд тусгах саналыг “Олон улсын худалдаа логистикийн төв” ХК-д тус тус хүргүүлэв.	
<b>Зорилт 2: 3.4.2. Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.</b>							
3.4.2.1. Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны контент бэлтгэж, гадаад дотоодод түгээн, цахим аялал жуулчлалыг хөгжүүлнэ.							
1.2.1.	<b>Арга хэмжээ-25:</b> Аялал жуулчлалын сурталчилгааны контент бэлтгэж, гадаад дотоодод түгээн Улаанбаатар хотыг сурталчлах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 25.0 сая.төг	Контентийн тоо	3	4	-Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/439 дүгээр захирамжийн хүрээнд Улаанбаатар хотын сурталчилгааны цуврал 22 контент нэвтрүүлгийн зураг авалтын ажлыг гүйцэтгэж байна. Энэ ажлын хүрээнд Улаанбаатар хотын аяллын контент хийх бэлтгэл ажлыг хангаж байна.	70%
1.2.2.	<b>Арга хэмжээ-26:</b> Аялал жуулчлалын гадаад сурталчилгааны цахим платформ гадаадын жуулчдад зориулсан <a href="http://www.visitulaanbaatar.net">www.visitulaanbaatar.net</a> /англи хэл/ дээрх цахим сайтыг хөгжүүлж, үйл ажиллагаагаа сурталчлах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 35.0 сая.төг	Хандалтын тоо	-	50.000	-Улаанбаатар хотыг гадаад улс оронд сурталчлах <a href="http://www.Visitulaanbaatar.net">www.Visitulaanbaatar.net</a> цахим хуудсанд хөгжүүлэлт хийж жуулчдад хэрэгцээт цаг үеийн шинж чанартай мэдээ, мэдээллийг тогтмол /англи хэл дээр бэлтгэн/ оруулж нийт 11.300 гаруй хүнд сурталчилсан. Цахим сайтын мэдээг эх сурвалжаас 5.2%, facebook хуудсанаас 30.9%, Google-ээс 10.5% үзэж, Улаанбаатар хотын өнгө төрхийг харуулах 360 градусын 4 багц 25 ширхэг зургийн санг үүсгэн байршуулж, нийслэлийн мэдээ мэдээллийн <a href="http://www.Ulaanbaatar.mn">www.Ulaanbaatar.mn</a> цахим хуудастай холбож үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан. - Гадаад сурталчилгааны мэдээ мэдээллийн цахим сэтгүүлийг /англи, монгол хэлээр/ бий болгох ажлыг “Ворлд Түдэй Медиа Групп” ХХК-аар гүйцэтгүүлж, <a href="http://www.Visitulaanbaatar.net">www.Visitulaanbaatar.net</a> холбох ажлыг зохион байгуулж байна.	70%
1.2.3.	<b>Арга хэмжээ-27:</b> Цайны замын төслийн хүрээнд Монгол-Орос-Хятад гурван улсын сайд нарын уулзалтыг хамтран зохион байгуулж, оролцох	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 20.0 сая.төг	Тоо	1	1	Хугацаа болоогүй.	

1.2.4.	<b>Арга хэмжээ-28:</b> Бүс нутгийн Олон Улсын Аялал жуулчлалын холбоонд элсэх санал хүргүүлэх	/-/	Саналын тоо	/-/	1	-Дэлхийн аялал жуулчлалын салбарын хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах, хот хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ болон туршлагыг түгээх зорилготой байгуулагдсан Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбоонд элсэх хүсэлт, байгууллагын танилцуулгыг Ази, номхон далайн бүс нутаг хариуцсан албан тушаалтанд хүргүүлж, Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбооны удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар шийдвэрлэж, элсүүлсэн батламжаа гардан авсан.	100%
3.4.2.2. Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд оролцож Улаанбаатар хотыг сурталчлан таниулна.							
1.2.5.	<b>Арга хэмжээ-29:</b> “ITB”, “Котфа”, “ФАТА”, “JATA”, “ITM” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, ОХУ, БНХАУ-ын аялал жуулчлалын өдөрлөгт оролцож Улаанбаатар хотыг сурталчлах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 200.0 сая.төг	Тоо	4	7	- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад зохион байгуулагддаг “Ай Ти Би Берлин” үзэсгэлэн ковид-19 цар тахлаас шалтгаалан виртуал орчинд цахимаар 2022 оны 3 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд зохион байгуулагдаж улс, хотуудын төрийн болон аж ахуйн нэгжийн төлөөллүүд оролцож зочин илтгэгчдийн хурал, семинарт цахимаар оролцов. - Монголын Аялал жуулчлалын холбооноос санаачлан Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл, Бусан, Чонжү хот болон Япон улсын Токио, Шизүока, Осака хотуудад 2022 оны 05 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монголын Аялал жуулчлалын форум” арга хэмжээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Гадаад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай” А/531 дүгээр захирамжийн дагуу Улаанбаатар хотын сурталчилгааны ажлыг Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл дахь Улаанбаатар хотын төлөөлөгчийн газар болон Монгол Улсаас Япон Улсад суугаа бүрэн эрхт Элчин сайдын яамаар дамжуулан Япон, Солонгос 200 ширхэг “Ulaanbaatar your gateway”	70%

						сэтгүүлийг шилдэг 100 тур операторын удирдлагуудад хүргэж Улаанбаатар хотыг сурталчлав.	
<b>Зорилт 3: 3.4.3. Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.</b>							
3.4.3.1. Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.							
1.3.1.	<b>Арга хэмжээ-30:</b> Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх контентийг агаарын тээврийн компани, зочлох үйлчилгээний байгууллагуудад байршуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 20.0 сая.төг	Аж ахуйн нэгжийн тоо	-	50	-Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй аялах видео контент, аяллын үед коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий 2 төрлийн контентыг зочлох үйлчилгээний 10 байгууллагын угтах үйлчилгээ, хүлээлгийн танхимд байршуулж, мөн агаарын хөлгийн бүхээг болон цахим сувгуудаар түгээх ажлыг зохион байгуулж байна.	50%
1.3.2.	<b>Арга хэмжээ-31:</b> Жуулчдад зориулсан санамж, гарын авлага тараах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 10.0 сая.төг	Тараах материал тоо	10.000	10.000	-Монгол улсад аялах хугацаандаа коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэм, зөвлөмжийг дагаж мөрдөх санамж, жуулчны мэдээллийн төвийн мэдээлэл, шаардлагатай утасны жагсаалт болон урьдчилан сэргийлэх санамж бүхий 2 төрлийн 500 санамжийг Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд болон зохион байгуулсан арга хэмжээний үеэр тараасан.	50%
1.3.3.	<b>Арга хэмжээ-32:</b> Аялал жуулчлалын салбарт мөрдөж буй үндэсний болон хотын стандартуудыг сурталчлах ажлыг зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 9.5 сая.төг	Тоо	3	4	-Улаанбаатар хотын “UCS1203B амралт, аялал жуулчлал: Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах шаардлага” хотын стандартыг газрын цахим хуудас, “Улаанбаатар хотын амралтын газар, жуулчны баазуудын нэгдсэн мэдээ, мэдээлэл” пэйж хуудаснуудад байршуулж, 1900 хүнд сурталчилсан. -Байгал орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/86 дугаар тушаалаар байгуулагдсан “Зэрэглэл тогтоох ажлын	50%

						хэсэг"-ийн бүрэлдэхүүнд ажиллаж 11 зочид буудалд “Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 5927:2008” стандартыг сурталчилж, үнэлгээ тогтоосон. -Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёл, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр Аялал жуулчлалын ур чадварын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран “Жуулчны баазын үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах нь” сэдэвт сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулж 41 жуулчны баазын удирдлагад “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” үндэсний стандарт, “UCS1203B амралт, аялал жуулчлал: Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах шаардлага” стандартуудыг сурталчилж ажиллаа.	
3.4.3.2. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад тавигдах ерөнхий шаардлагад нэмэлт оруулах замаар и-баримтад бүрэн холбож, нийслэл хотын албан татвараас төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ.							
1.3.4.	<b>Арга хэмжээ-33:</b> Зочид буудал, дэн буудлын үйлчилгээний стандартын төсөлд санал боловсруулж хүргүүлэх	-	Хүргүүлсэн саналын тоо	-	2	-Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2021 оны А/23 тушаалаар байгуулсан “Зочид буудлын ерөнхий шаардлага MNS4588:2008”, “Аялал жуулчлал. Дэн буудлын ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартуудыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж 11 төрийн байгууллага болон 7 төрийн бус байгууллагаас санал авч стандартуудын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын техникийн хороогоор хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.	100%
1.3.5.	<b>Арга хэмжээ-34:</b> Аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг и-баримтад холбох ажлыг хамтран зохион байгуулж,	-	Орлого	7.346.3	9.000.0	-Аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхэлдэг зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны бааз и-баримтад холбуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, нийслэл хотын албан татварт 2022 оны I	70%

	нийслэл хотын албан татвараас төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх					улирлын байдлаар 2.505.842.320 төгрөг төвлөрөөд байна.	
3.4.3.3. Салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төрөлжсөн сургалтыг зохион байгуулна.							
1.3.6.	<b>Арга хэмжээ-35:</b> Зочид буудал, зоогийн газрын үзэсгэлэн, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах олон улсын тэмцээн зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 50.0 сая.төг	Оролцогч, сонирхогчдын тоо	-	4000	-Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах тухай” А/530 дугаар захирамжийн хүрээнд тус газраас Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Зочид буудлуудын холбоотой хамтран “HOSPITALITY-2022” нэгдсэн арга хэмжээг “Зочид буудал, зоогийн газрын хангамжийн үзэсгэлэн, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн, “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт”, “Зочлох үйлчилгээний салбарын цахим шилжилт, шийдэл” хэлэлцүүлэг” гэсэн 4 чиглэлээр 2022 оны 05 дугаар сарын 13,14-ний өдрүүдэд Улаанбаатар зочид буудлын үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулав. -“Зочид буудал, зоогийн газрын хангамжийн үзэсгэлэн”-д орон нутгийн Аялал жуулчлалын газрууд, салбарын мэргэжлийн холбоод, зочлох үйлчилгээний чиглэлээр боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургууль зэрэг 45 байгууллага, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээнд зочид буудлуудын 41 ажилтан, “Зочлох үйлчилгээний салбарын цахим шилжилт, шийдэл” хэлэлцүүлэг”-т зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 60 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл оролцсон бөгөөд арга хэмжээг 5000 гаруй иргэн үзэж, сонирхож, 10 гаруй телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахимаар 42.000 гаруй хүнд сурталчилсан.	100%
1.3.7.	<b>Арга хэмжээ-36:</b> Жуулчдад үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллага болон салбарын хүний нөөцийг чадавхжуулах ажлыг	Нийслэлийн төсөв	Сургалтад хамрагдсан хүний тоо	650	450	-Швейцарын хөгжлийн агентлаг (SDC), "Ай Хотел" ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд аялал жуулчлалын салбарын нэгдсэн мэдээллийн сан, цахим экосистемийн хөгжлийг дэмжих замаар цахим сургалтын	50%

	мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах					<p>платформ бий болгох, салбар дахь бизнес эрхлэгчдийн цахим хэрэглээний чадавх мэдлэгийг дээшлүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор “My Hotel-Аялал жуулчлал, байрших үйлчилгээний салбар дахь цахим шилжилт төсөл” онлайн сургалтыг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж, 120 хүнийг сургалтад хамруулав.</p> <p>- Зочлох үйлчилгээний салбарын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, салбарын үйлчилгээний ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, ажлын үр дүнг сайжруулах, мэргэжлийн ажилтнуудтай ажлын байранд мэдлэг, туршлага солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор зочин хүлээн авагч, өрөө үйлчилгээ, зөөгч, бартендер ажил мэргэжлээр 41 ажилтныг хамруулж батламж олгосон.</p> <p>- Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёл, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр Аялал жуулчлалын ур чадварын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран “Жуулчны баазын үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах нь” сэдэвт сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулж 41 жуулчны баазын удирдлагыг хамруулж, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 3 удаагийн сургалтад 201 хүн хамруулав.</p>	
<b>Зорилт 4: 3.4.4. “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж, хэрэгжүүлнэ.</b>							
1.4.1	<p><b>Арга хэмжээ-37:</b>  “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж хэрэгжүүлнэ.  “Найрсаг Улаанбаатар-2” нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга</p>	<p>ҮАБСБҮХ,  ХСДИТАХЗ  20.0 сая.төг</p>	Тоо	-	1	<p>-Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/599 дүгээр захирамжаар нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх “Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг батлуулж, 7 зорилтын 77 үйл ажиллагааг 2022-2025 оны хооронд хэрэгжүүлэх төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх холбогдох байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	100%



	хэмжээг боловсруулж, батлуулах						
1.4.2	<b>Арга хэмжээ-38:</b> “Нэг жуулчин-Нэг мод” жуулчны төглийг хот орчимд бий болгох	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 50.0 сая.төг	Тоо	-	1	-Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Нийслэлийн иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, байгалийн сайханд эрүүл орчинд амрах, зугаалах нөхцөлийг бий болгох, гадаад, дотоодын аялагч, амрагчдад мод тарих боломжийг бүрдүүлэх зорилгоор “Сая жуулчин-Сая мод” аяны хүрээнд “Нэг жуулчин-Нэг мод” жуулчин төглийг Монголын Аялал жуулчлалын холбоо, аялал жуулчлалын 24 байгууллагатай хамтран Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд бий болгож, мод тарих нээлтийн өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, жуулчин төгөлд гацуур, шинэс, агч, нарс, хус, гүйлс, монос, нохойн хошуу, тэхийн шээг, паркийн сарнай зэрэг нийт 14 төрлийн 380 гаруй мод, бут тарьж суулгалаа.	100%
1.4.3	<b>Арга хэмжээ-39:</b> Бүх нийтийн аяллын боловсролыг нэмэгдүүлэх аян зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 10.0 сая.төг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	-Нийслэлийн хэмжээнд соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Аян зохион байгуулах” А/648 дугаар захирамжийг батлуулж, “Бүх нийтийн аяллын боловсролыг нэмэгдүүлэх” аянг “Нона фамили” ХХК-тай хамтран хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. -“Хотын соёлыг төлөвшүүлж, түгээн дэлгэрүүлэх” цахим аяны хүрээнд байгаль дэлхийгээ хайрлан, эко амьдралын хэв маягийг хэвшүүлэхийг уриалан байгаль орчноо хайрлах 50 энгийн арга, соёлтой, ул мөргүй аялцгаая зурагт мэдээлэл 3, видео танилцуулга 3 бэлтгэн газрын цахим хуудаст байршуулан 8288 хүнд сурталчилсан.	50%
<b>Зорилт 5: 3.4.5. “Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.</b>							

1.5.1	<b>Арга хэмжээ-40:</b> “Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. “Шинэ хэвийн байдал” нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх	Нийслэлийн төсөв 100.0	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	-“Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Аялал жуулчлалын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдуулан батлуулахаар хүлээгдэж байна. -Энэ хүрээнд нийслэлийн Татварын газар, нийслэлийн Нийгмийн даатгалын газруудаас санал авч ажиллаж байна	50%
<b>2.Төрийн үйлчилгээний чиглэлээр:</b>							
2.1.	<b>Арга хэмжээ-41:</b> “Улаанбаатар травэл экспо-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 10.0 сая.төг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	-Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/460 дугаар захирамжийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран дотоодын аялагчдад дотоод, гадаадын аяллын бүтээгдэхүүн, 21 аймгийн аялал жуулчлалын хөтөлбөр маршрут мэдээ мэдээлэл, үйлчилгээг нэг цэгээс аялагч, иргэдэд хүртээмжтэй хүргэх, хариуцлагатай аялагчийг төлөвшүүлэх бүх нийтийн аяллын боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Улаанбаатар травэл экспо-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг “Төрсөн нутгаараа аялъя” уриан доор 2022 оны 05 дугаар сарын 27,28,29-ний өдрүүдэд 8 дахь жилдээ “Мишээл экспо” төвд зохион байгуулав. - Үзэсгэлэнд 10 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, тус аймгуудад үйл ажиллагаа эрхэлдэг аялал жуулчлалын байгууллагууд зэрэг 106 байгууллага оролцож, нийт 7000 гаруй хүн үзэж сонирхсон.	100%
2.2.	<b>Арга хэмжээ-42:</b> Жуулчны улирлыг уртасгах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор	Байгууллагын төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	Хугацаа болоогүй.	-

	“Улаанбаатарын хөнгөлөлт” аяныг зохион байгуулах						
2.3.	<b>Арга хэмжээ-43:</b> Улаанбаатар хотын аялал жуулчлалын дата мэдээллийн санг үүсгэх	Байгууллагын төсөв	Тоо	-	1	-Улаанбаатар хотод идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллага, олон улсын чанартай зохион байгуулагддаг аялал жуулчлалын томоохон үзэсгэлэн, арга хэмжээ болон хот орчмын болон аймаг орон нутгийн очиж үзэж болох дурсгалт газрууд, аяллын маршрут, тусгай сонирхлын аялал зохион байгуулдаг сайн дурын клубүүдийн судалгааг шинэчлэн гаргаж мэдээллийн сан үүсгэсэн. -Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвд 10 төрлийн 1500 гаруй байгууллагын нэгдсэн мэдээллийн санг тогтмол шинэчлэн гадаад, дотоодын иргэд, жуулчдыг хэрэгцээт мэдээллээр ханган ажиллаж байна.	70%
2.4.	<b>Арга хэмжээ-44:</b> Сити тур төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Байгууллагын төсөв 80.0 сая.төг	Хүний тоо	-	2500	-“Сити тур” төслийг хүрээнд Улаанбаатар хот орчмын аяллын 26 маршрутыг баталж, хүүхэд, багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дотоодын иргэдийн аяллын боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор “Сити тур” хотын автобустай аяллыг Монголын Дауны холбоо, “Ид шидийн орон” ТББ, Монгол Улсын Их сургууль, “MNB WORLD” ТВ-ийн нэвтрүүлгийн редакц, Нийслэлийн Авто замын түгжрэлийг бууруулах нэгж зэрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж “Сити тур” төсөлд 2555 хүнийг хамруулсан.	100%
2.5.	<b>Арга хэмжээ-45:</b> Аялал жуулчлалын зочлох үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийг бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 20.0 сая.төг	Аж ахуйн нэгжийн тоо	-	250	-Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/987 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйлчилгээний байгууллагуудыг системд хамруулах, бүртгүүлэх зорилгоор байгууллагын <a href="http://www.ub.gov.tourism.mn">www.ub.gov.tourism.mn</a> цахим хуудас, газрын facebook хуудсанд мөрдөгдөж буй стандарт, тавигдах шаардлагыг ханган татварын албанд бүртгүүлснээр нийслэлийн нутаг дэвсгэрт	50%

						байр сууцны үйл ажиллагаа эрхлэх талаар холбогдох мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллагуудад өгч, арга зүйн удирдлагаар ханган ажилласан. - “Онлайн бизнес” төвийн Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн нэгдсэн системд тайлант хугацаанд 155 аж ахуйн нэгж, байгууллага зочид буудал, дэн буудал, амралтын газрын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлэх хүсэлт гаргасан бөгөөд үүнээс шийдвэрлэсэн-30, шилжүүлсэн-112, судалж байгаа -0, илгээсэн-0, татгалзсан-2, буцаасан 11 гэсэн явцтай байна.	
2.6.	<b>Арга хэмжээ-46:</b> Үндэсний их баяр наадам үзэх гадаадын жуулчдын билетийг хуваарилах	-	Тасалбарын тоо	-	1954	Хугацаа болоогүй.	
2.7.	<b>Арга хэмжээ-47:</b> Албан хэрэг хөтлөлтийг заавар, журам, стандартын дагуу зохион бүрдүүлж хөтлөх, ирсэн бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэх	-	Шийдвэрлэлт ийн хувиар	90%	95%	-Тус газарт 2022 оны эхний хагас жилийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуй нэгжээс ирүүлсэн 280 албан бичгийг бүртгэж, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцүүлэн 308 албан бичгийг явуулсан. -Нийт ирүүлсэн 280 албан бичгээс шийдвэрлэсэн 267, судалж байгаа 13 бичиг, хугацаа хоцроож шийдвэрлэсэн албан бичиг байхгүй, албан хэрэг хөтлөлтийн зөрчил өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 нэгжээр буурсан бөгөөд шийдвэрлэлт 90.4 %-тай байна.	100%
2.8.	<b>Арга хэмжээ-48:</b> Иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал гомдлыг шийдвэрлэх	-	Шийдвэрлэлт ийн хугацаагаар	7 хоног	7 хоног	-Тус газарт 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 8 өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авч 100% шийдвэрлэсэн. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцад Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга, өргөдөл, гомдол хариуцсан албан хаагч тогтмол хяналт тавьж, тайлан мэдээг сар бүр гарган Газрын даргад танилцуулан ажилласан. Өргөдөл гомдлын	50%

						шийдвэрлэлтийн дундаж хугацаа 11 хоног 4 цаг 32 минут байна.	
2.9.	<b>Арга хэмжээ-49:</b> Төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх	-	Орлого бүрдүүлсэн байдал	20 сая	60 сая	-Тус газрын 2022 оны батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх төсвийн орлогыг “Сити тур” төслөөс төвлөрүүлэх төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд 5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.	30%
<b>3. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр:</b>							
3.1.	<b>Арга хэмжээ-50:</b> Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	90%	95%	- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хүрээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт 63.3%, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 1 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 63.3%, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 5 зорилтын 11 арга хэмжээний биелэлт 57.0%, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2022 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний 1 зорилтын 15 арга хэмжээний биелэлт 65.0%, “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 1 зорилтын 19 арга хэмжээний биелэлт 62.0%-ийн хэрэгжилттэй байна. -Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 90.0%, захирамжлалын баримт	100%

						бичгийн 86.2% хэрэгжилттэй үнэлэгдэж, тайлан мэдээг хугацаанд нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн бөгөөд <a href="http://www.monitoring.ulaanbaatar.mn">www.monitoring.ulaanbaatar.mn</a> цахим программаар тайлагнасан.	
3.2.	<b>Арга хэмжээ-51:</b> “Албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	Байгууллагын төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	95%	100%	-Байгууллагын албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны сургалтын төлөвлөгөөний хүрээнд “YES МОНГОЛ БИЧИГ” аяны хүрээнд “Монгол бичгийн сургалт”-ыг 3 сарын хугацаанд, “Хүүхэд хүмүүжүүлэх арга ба сэтгэл зүй”, “Дипломат ёслол”, “Хамтын оролцоотой аялал жуулчлал”, “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах нь” сэдэвт 5 удаагийн сургалт, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Хууль эрх зүй”, “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Алсын хараа-2050”, “RISE-Academy” зэрэг 8 удаагийн сургалт, гадаад олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран “Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах нь”, “Ахисан түвшний Жендерийн дүн шинжилгээ”, “Eco-cultural Tourism for Local Activation” 5 удаагийн сургалт хамтран зохион байгуулж, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор 113 албан хаагч хамрагдсан. - “Хүний нөөцийн хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” А/641 дүгээр захирамжийн дагуу 4 албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгуулсан.	100%



3.3.	<b>Арга хэмжээ-52:</b> Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	-Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/22 дугаар захирамжаар баталсан “2022 оны төсвийн орлогын сарын хуваарь”, 2022 оны төсвийн зарлагын санхүүжилтийн хуваарь”, “Нийслэлийн 2022 оны төсвийн төсөв хоорондын харилцааны сарын хуваарь”-ийн дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулан сар бүр төсвийн гүйцэтгэл өглөг, авлагын мэдээг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.	100%
3.4.	<b>Арга хэмжээ-53:</b> Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан, төсвийн ил тод байдлыг хангах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	-Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган байгууллагын жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, төсвийн хэмнэлт хэтрэлт, аудитын зөвлөмжийн тайлан, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд тайлагнаж, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 17, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр 12, бусад чиглэлээр 15 буюу 44 ажлын мэдээллийг <a href="http://www.info.shilendans.gov.mn">www.info.shilendans.gov.mn</a> цахим санд оруулж ил тод байдлыг ханган ажилласан.	100%
3.5.	<b>Арга хэмжээ-54;</b> Авлигалаас урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэн ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	-Тус газрын бүтэц зохион байгуулалт, албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт орж батлагдсантай холбогдуулан ахлах мэргэжилтний албан тушаалд нэр дэвшсэн 2 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг <a href="http://www.meduuleg.iaac.mn">www.meduuleg.iaac.mn</a> системд бүртгэж мэдүүлгийг хянуулсан бөгөөд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг тайлагнадаг 5 албан тушаалтан хугацаандаа мэдүүлсэн. -Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган авлигын	100%

						шинж чанартай зөрчил, хэрэгт холбогдсон албан тушаалтан байхгүй болно.	
3.6.	<b>Арга хэмжээ-55;</b> Байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийг шинэчилж, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	-Байгууллагын дэргэдэх “Ёс зүйн зөвлөл”-ийг газрын даргын 2022 оны А/14 дүгээр тушаалын шинэчлэн баталж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, байгууллагын “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг цахим хуудаст байршуулж, дүрэм, журмын мөрдүүлэн ажиллаж байна. -Удирдлагын академиас зохион байгуулсан “Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах нь” сэдэвт сургалт, Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтад байгууллагын “Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг хамруулсан.	100%
3.7.	<b>Арга хэмжээ-56;</b> Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж, гарсан сул орон тоог нөхөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	-Албан хаагчдын нэр, албан тушаал, харилцах утас, цахим хаяг, байгууллагын мөрдөгдөж байгаа дүрэм, журмыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулав. -Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-д хүрээнд тус газрын 14 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж хянуулан танилцуулж, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 323 дугаар тогтоолын хүрээнд газрын даргын 2022 оны А/24 дүгээр тушаалаар төрийн захиргааны /ТЗ/ 14, төрийн үйлчилгээний /ТҮ/ 3 нийт 17 албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан бөгөөд тайлант хугацаанд сул орон тоо гараагүй.	100%
3.8.	<b>Арга хэмжээ-57;</b>	-	Батлагдсан журмын тоо	-	1	Хугацаа болоогүй.	-



	Байгууллагын Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг шинэчлэн батлуулах						
3.9.	<b>Арга хэмжээ-58;</b> Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар, бусад холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	Нийслэлийн удирдах ажилтнуудын 8 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн үүрэг, даалгавраас чиг үүргийн хүрээнд заалт тус бүрээр биелэлтийг ханган, хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь <a href="http://www.ulaanbaatar.mn">www.ulaanbaatar.mn</a> программаар тайлагнан ажиллав.	100%
Нийт хэрэгжилтийн хувь:							80.8%

ТАНИЛЦСАН  
ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Х.СОДНОМДЭМБЭРЭЛ

ТАЙЛАН НЭТГЭСЭН:  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ,  
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ